


Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн
264 дүгээр тушаалын долдугаар хавсралт



ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаанд үүсэх тээвэрлэгч, тээвэр зуучлагчийн хоорондын харилцааг Төмөр замын тээврийн тухай хууль, Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, багц дүрэм, бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.2. Төмөр замын тээвэр зуучлагч /цаашид "тээвэр зуучлагч" гэх/ ба үйлчлүүлэгчийн хоорондын харилцааг Иргэний хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон тэдгээрийн хооронд байгуулсан тээвэр зуучлалын гэрээгээр зохицуулах бөгөөд энэхүү журмаар зохицуулах хүрээнд хамаарахгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР ЗУУЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2.1. Төмөр замын тээвэр зуучлагч нь Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журамд заасны дагуу Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байна.

2.2. Төмөр замын тээвэр зуучлагч нь үйлчлүүлэгчийг төлөөлж тээвэрлэгчтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу тээврийн гэрээ байгуулна.

2.3. Тээвэр зуучлагч нь тээвэрлэгч болон үйлчлүүлэгчийн хооронд дараахь үйлчилгээг үзүүлэхэд зуучилна.


2.3.1. зуучлалын даалгаврын дагуу тээврийн технологийн маршрут, схемийн эдийн засгийн үндэслэлийг зохиох;

2.3.2. вагон, чингэлэг захиалах, түрээслэх;

2.3.3. тээврийн бичиг баримт, түүнд дагалдах бичиг баримтуудыг бүрдүүлэх;

2.3.4. тээврийн хөлс, бусад холбогдох хөлс, хураамжийн тооцоог хийх;

2.3.5. ачааны даатгалтай холбоотой бичиг баримт бүрдүүлэлт, ачаа дутах, эвдэрч ирсэн тохиолдолд тогтоосон журмын дагуу тээврийн акт болон бусад акт тавихтай холбоотой бичиг баримтын бүрдүүлэлтэд оролцох;



2.3.6. төмөр замаар ачаа тээвэрлэх журамд заасны дагуу ачааны хаяг солих;
2.3.7. үйлчлүүлэгчид тээвэрлэлтийн явц, ачааны байршлын талаар мэдээлэл өгөх;

2.3.8. ачааны марклалд хяналт тавих, байгуулах тээврийн хэрэгсэл болон ачаа хадгалах агуулахыг ломбодох;

2.3.9. Бусад нэмэлт үйлчилгээ.

2.4. Тээвэр зуучлалын гэрээнд өөрөөр заагаагүй бол тээвэр зуучлагч нь үйлчлүүлэгчийн өмнөөс тээвэрлэлтийг зохион байгуулахад шаардлагатай тохиолдолд дараахь ажиллагааг гүйцэтгэнэ:

2.4.1. ачаа тээврийн захиалгыг тээвэрлэгчид өгөх, ачааг тээвэрлэх, хадгалах, тээврийн нэг төрлөөс нөгөө төрөлд шилжүүлэх болон тээвэрлэлтийг гүйцэтгэхэд шаардлагатай бусад асуудлыг тээвэрлэгчтэй тохиролцох;

2.4.2. тээвэрлэлтийг гүйцэтгэхэд шаардлагатай гаалийн болон бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

2.5. Тээвэр зуучлагч нь энэхүү журмын 2.3-т заасан төмөр замын тээвэр зуучлалын үйлчилгээг үзүүлэхдээ Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, MNS 5523:2013 стандарт, дүрэм журам, Монгол Улсын Олон улсын гэрээг мөрдөх ба аюулгүй, хурдан шуурхай үйлчлэх зарчмыг баримтална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТЭЭВЭРЛЭГЧ, ТЭЭВЭР ЗУУЧЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаанд үүсэх тээвэрлэгч, тээвэр зуучлагчийн эрх, үүргийг Төмөр замын тээврийн тухай хууль, Иргэний хууль, Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, багц дүрэм зэрэг холбогдох хууль, тогтоомж, олон улсын гэрээгээр зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТЭЭВЭРЛЭГЧ, ТЭЭВЭР ЗУУЧЛАГЧИЙН ХАРИУЦЛАГА

4.1. Тээвэрлэгч, тээвэр зуучлагч нь тээврийн гэрээ болон энэхүү журамд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үүсэх хохирлыг Иргэний хууль болон Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, Төмөр замаар ачаа тээвэрлэх журам зэрэг холбогдох олон улсын гэрээ, хууль тогтоомжид заасны дагуу барагдуулна.

4.2. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---

